

ИХЭРМӨРӨН-АУДИТ ХХК



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Тариалан сумын эрүүл мэндийн төвийн
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХӨА-2026/115/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Мөрөн сум

2026 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр

Утас: 99089114 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn

Аудитор: Б.Ариунтуяа

Утас: 99036832 Цахим хаяг: ariuntuyab@audit.gov.mn

Ихэрмөрөн-Аудит ХХК-ийн захирал Б.Мядагмаа

Утас: 99389208 Цахим хаяг: b_myadagmaa@yahoo.com

Аудитор Ц.Мөнхтуяа

Утас: 99382220 Цахим хаяг: munkhtuya2220@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2026.02.25 № 01/29

танай _____-ны № _____-т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ТАРИАЛАН
СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ А.ТУНГАЛАГ
ТАНАА

Хараат бус аудиторын дүгнэлт

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Тариалан сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тариалан сумын Эрүүл мэндийн төв нь тайлант онд Эрүүл мэндийн даатгалын сангаас авах 265,527.3 мянган төгрөгийн санхүүжилтийг авлагаар бүртгэсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Аудитаар нийт 35,764.0 мянган төгрөгийн 6 алдаа, зөрчлийг илрүүлснээс 13,100.2 мянган төгрөгийн 2 алдааг залруулж, 22,663.8 мянган төгрөгийн 4 зөрчилд зөвлөмж хүргүүлээ.

Бусад асуудлын хэсэг

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас Тариалан сумын Эрүүл мэндийн төвтэй байгуулсан анхан шатны тусламж үйлчилгээг худалдан авах 2025 оны гэрээний биелэлтийг 93.3 хувьтай дүгнэсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А. ЭРДЭНЭБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Данс	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	544,170,032.47	420,863,614.44
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	22,474,043.99	41,567,656.61
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	22,474,043.99	41,567,656.61
3121	Төгрөг	22,474,043.99	41,567,656.61
31211	Төрийн сангийн харилцах	22,474,043.99	41,567,656.61
33	АВЛАГА	360,347,779.82	265,660,013.50
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	456,888.30	132,720.63
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	359,890,891.52	265,527,292.87
35	БАРАА МАТЕРИАЛ	161,348,208.66	113,635,944.33
351	Түүхий эд материал	65,587,855.45	48,216,228.57
35130	Эм боох материал	65,587,855.45	48,216,228.57
354	Хангамжийн материал	94,969,826.21	65,419,715.76
35410	Бичиг хэргийн материал	4,052,710.00	778,950.00
35420	Аж ахуйн материал	33,071,302.46	17,338,445.00
35430	Сэлбэг хэрэгсэл	00.00	390,000.00
35440	Түлш, шатах тослох материал	2,000,000.00	00.00
35460	Хүнсний материал	26,561.00	152,600.00
35470	Бусад хангамжийн материал	55,819,252.75	46,759,720.76
35600	Мал амьтад	790,527.00	00.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	954,615,552.42	1,585,478,440.12
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	954,615,552.42	1,585,478,440.12
392	Биет хөрөнгө	931,382,519.17	1,562,355,406.91
39201	Барилга, байгууламж, орон сууц	533,369,047.61	533,369,047.61
39202	Хуримтлагдсан элэгдэл	-132,751,548.04	-159,622,514.80
39203	Авто-тээврийн хэрэгсэл	245,475,058.47	239,665,366.47
39204	Хуримтлагдсан элэгдэл	-47,326,736.86	-85,660,279.14
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	491,930,621.31	1,101,538,074.31
39206	Хуримтлагдсан элэгдэл	-173,732,241.70	-227,056,801.26
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	53,985,959.00	184,103,822.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-39,567,640.62	-23,981,308.28
393	Биет бус хөрөнгө	23,233,033.25	23,123,033.21
39301	Програм хангамж	725,000.00	725,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-404,166.75	-514,166.79
39303	Бусад биет бус хөрөнгө	22,912,200.00	22,912,200.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,498,785,584.89	2,006,342,054.56
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	68,259,737.38	9,822,000.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	68,259,737.38	9,822,000.00
413	Өглөг	68,259,737.38	9,822,000.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	1,578,435.38	00.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	47,742,902.00	00.00
4136	Бусад өглөг	18,938,400.00	9,822,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	17,288,400.00	00.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	1,650,000.00	9,822,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,430,525,847.51	1,996,520,054.56
51	Засгийн газрын хувь оролцоо	1,430,525,847.51	1,996,520,054.56
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	332,460,354.00	332,460,354.00
51101	Өмч: - төрийн	332,460,354.00	332,460,354.00
512	Хуримтлагдсан үр дүн	674,646,566.66	1,240,640,773.71
51210	Өмнөх үеийн үр дүн	674,646,566.66	674,646,566.66
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	565,994,207.05
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	423,418,926.85	423,418,926.85
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,498,785,584.89	2,006,342,054.56

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,143,373,463.96	2,638,763,518.10
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	406,981,293.46	834,069,881.20
120	Нийтлэг татварын бус орлого	406,981,293.46	834,069,881.20
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	406,981,293.46	834,069,881.20
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	79,302,000.00	79,703,569.06
1200017	Үнэ төлбөргүй хүлээж авсан орлого-үндсэн хөрөнгө	289,594,187.11	713,554,000.00
1200018	Үнэ төлбөргүй хүлээж авсан орлого-бараа материал	38,085,106.35	40,812,312.14
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,736,392,170.50	1,804,693,636.90
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	47,383,300.00	58,320,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	47,383,300.00	58,320,600.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	1,689,008,870.50	1,746,373,036.90
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,689,008,870.50	1,746,373,036.90
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,659,563,776.31	2,072,769,311.05
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,577,127,776.31	1,990,292,986.42
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,577,127,776.31	1,990,292,986.42
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,035,075,440.00	1,155,925,741.24
210101	Үндсэн цалин	585,265,749.35	643,347,648.70
210102	Нэмэгдэл	333,543,775.40	382,690,881.54
210103	Унаа хоолны хөнгөлөлт	22,186,000.00	38,010,000.00
210104	Урамшуулал	94,079,915.25	91,877,211.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	132,720,585.64	148,746,017.06
210201	Тэтгэврийн даатгал	87,720,808.42	96,966,962.32
210202	Тэтгэмжийн даатгал	10,116,774.70	11,348,139.56
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,629,272.96	12,286,279.54
210204	Ажилгүйдлийн даатгал	5,269,897.09	5,311,577.46
210205	Эрүүл мэндийн даатгал	19,983,832.47	22,833,058.18
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	43,883,300.00	55,515,529.37
210301	Гэрэл, цахилгаан	5,774,600.00	7,777,915.77
210302	Түлш, халаалт	36,108,700.00	45,337,613.60
210303	Цэвэр, бохир ус	2,000,000.00	2,400,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	75,446,709.50	180,801,047.59
210401	Бичиг хэрэг	2,035,500.00	8,914,160.00
210402	Тээвэр, шатахуун	47,938,500.00	59,695,350.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,432,445.50	3,625,528.48
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	319,000.00	13,946,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	21,721,264.00	26,600,563.00
210408	Бараа материал акталсны зардал	00.00	68,018,546.11
2105	Нормативт зардал	192,460,173.25	213,703,970.86
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	159,808,341.25	177,369,428.86
210502	Хоол, хүнс	32,651,832.00	36,334,542.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	18,185,100.00	37,543,750.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	00.00	16,660,000.00
210604	Урсгал засвар	18,185,100.00	20,883,750.00
2107	Томилт, зочны зардал	5,328,000.00	7,850,000.00

210702	Дотоод албан томилолт	5,328,000.00	7,850,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,041,968.00	21,695,768.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,301,100.00	18,283,850.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	2,304,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	129,000.00	193,350.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	49,500.00	106,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	12,800.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	478,000.00	737,000.00
210807	Газрын төлбөр	71,568.00	71,568.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	70,986,499.92	168,511,162.30
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,211,820.00	367,350.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	66,774,679.92	168,143,812.30
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	82,436,000.00	82,476,324.63
2132	Бусад урсгал шилжүүлэг	82,206,000.00	77,671,254.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	42,847,254.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	82,206,000.00	34,824,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	230,000.00	4,805,070.63
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	230,000.00	4,805,070.63
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	483,809,687.65	565,994,207.05
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	483,809,687.65	565,994,207.05

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,485,840,591.98	1,993,286,877.70
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	79,302,000.00	94,229,642.15
120	Нийтлэг татварын бус орлого	79,302,000.00	94,229,642.15
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	79,302,000.00	94,229,642.15
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	79,302,000.00	94,229,642.15
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,406,538,591.98	1,899,057,235.55
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	47,383,300.00	58,320,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	47,383,300.00	58,320,600.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	1,359,155,291.98	1,840,736,635.55
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,359,155,291.98	1,840,736,635.55
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,532,867,372.76	1,888,740,565.08
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,532,867,372.76	1,888,740,565.08
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,450,431,372.76	1,806,264,240.45
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,033,833,892.92	1,162,972,058.11
210101	Үндсэн цалин	584,015,720.77	636,447,086.86
210102	Нэмэгдэл	333,552,256.90	429,459,444.14
210103	Унаа хоолны хөнгөлөлт	22,186,000.00	32,569,638.88
210104	Урамшуулал	94,079,915.25	64,495,888.23
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	132,720,585.64	147,658,040.99
210201	Тэтгэврийн даатгал	87,720,808.42	96,966,962.32
210202	Тэтгэмжийн даатгал	10,116,774.70	11,348,139.56

210203	ҮОМШӨ-ний даатгал	9,629,272.96	12,286,279.54
210204	Ажилгүйдлийн даатгал	5,269,897.09	5,311,577.46
210205	Эрүүл мэндийн даатгал	19,983,832.47	21,745,082.11
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	43,883,300.00	53,515,529.37
210301	Гэрэл, цахилгаан	4,394,100.69	7,777,915.77
210302	Түлш, халаалт	37,489,199.31	43,337,613.60
210303	Цэвэр, бохир ус	2,000,000.00	2,400,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	65,199,850.50	109,121,288.48
210401	Бичиг хэрэг	3,156,800.00	4,504,400.00
210402	Тээвэр, шатахуун	42,091,650.00	65,240,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,212,445.50	3,845,528.48
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,229,200.00	13,976,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	12,509,755.00	21,554,260.00
2105	Нормативт зардал	140,378,835.70	226,188,955.50
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	119,531,335.70	154,998,908.50
210502	Хоол, хүнс	20,847,500.00	40,923,047.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	30,267,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	17,065,100.00	61,728,250.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	17,067,500.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	00.00	16,660,000.00
210604	Урсгал засвар	17,065,100.00	28,000,750.00
2107	Томилолт, зочны зардал	3,798,000.00	9,500,000.00
210702	Дотоод албан томилолт	3,798,000.00	9,500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,041,968.00	22,479,868.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,301,100.00	18,463,850.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	2,304,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	129,000.00	193,350.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	49,500.00	106,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	12,800.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	478,000.00	737,000.00
210807	Газрын төлбөр	71,568.00	71,568.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	00.00	604,100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10,509,840.00	13,100,250.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,509,840.00	13,100,250.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	82,436,000.00	82,476,324.63
2132	Бусад урсгал шилжүүлэг	82,206,000.00	77,671,254.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	42,847,254.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	82,206,000.00	34,824,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	230,000.00	4,805,070.63
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	230,000.00	4,805,070.63
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	-47,026,780.78	104,546,312.62
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	49,159,000.00	85,452,700.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	49,159,000.00	85,452,700.00
2200	Дотоод эх үүсвэрээр	49,159,000.00	85,452,700.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	49,159,000.00	85,452,700.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-49,159,000.00	-85,452,700.00

	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>00.00</u>	<u>00.00</u>
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>00.00</u>	<u>00.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-96,185,780.78	19,093,612.62
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	118,659,824.77	22,474,043.99
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	22,474,043.99	41,567,656.61

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	/ төгрөгөөр /
				Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	332,460,354.00	430,241,795.15	-105,340,326.56	657,361,822.59
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	259,437,843.54	259,437,843.54
2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	332,460,354.00	423,418,926.85	674,646,566.66	1,430,525,847.51
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	565,994,207.05	565,994,207.05
2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	332,460,354.00	423,418,926.85	1,240,640,773.71	1,996,520,054.56

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Улсын төсвийн гүйцэтгэл:

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	төгрөгөөр	
				Хувь	Зөрүү
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	2,270,069,100.00	1,934,966,277.70	85.24	335,102,822.30
12	Татварын бус орлого	2,270,069,100.00	1,934,966,277.70	85.24	335,102,822.30
120	Нийтлэг татварын бус орлого	125,263,400.00	94,229,642.15	75.23	31,033,757.85
120010	Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/	125,263,400.00	94,229,642.15	75.23	31,033,757.85
122	Тусламжийн орлого	2,144,805,700.00	1,840,736,635.55	85.82	304,069,064.45
122001	Хандив тусламж /дотоод/	2,144,805,700.00	1,840,736,635.55	85.82	304,069,064.45
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,292,543,200.00	1,915,872,665.08	83.57	376,670,534.92
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,292,543,200.00	1,915,872,665.08	83.57	376,670,534.92
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,168,855,200.00	1,838,201,411.08	84.75	330,653,788.92
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,377,733,800.00	1,162,972,058.11	84.41	214,761,741.89
210101	Үндсэн цалин	732,256,700.00	636,447,086.86	86.92	95,809,613.14
210102	Нэмэгдэл	474,539,400.00	429,459,444.14	90.50	45,079,955.86
210103	Унаа хоолны хөнгөлөлт	46,257,900.00	32,569,638.88	70.41	13,688,261.12
210104	Урамшуулал	124,679,800.00	64,495,888.23	51.73	60,183,911.77
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	182,082,600.00	147,658,040.99	81.09	34,424,559.01
210201	Тэтгэврийн даатгал	117,545,700.00	96,966,962.32	82.49	20,578,737.68
210202	Тэтгэмжийн даатгал	14,516,400.00	11,348,139.56	78.17	3,168,260.44
210203	ҮОМШӨ-ний даатгал	13,729,600.00	12,286,279.54	89.49	1,443,320.46
210204	Ажилгүйдлийн даатгал	7,258,200.00	5,311,577.46	73.18	1,946,622.54
210205	Эрүүл мэндийн даатгал	29,032,700.00	21,745,082.11	74.90	7,287,617.89
2104	Хангамж, бараа материалын зардал	124,686,900.00	109,121,288.48	87.52	15,565,611.52
210401	Бичиг хэрэг	6,550,000.00	4,504,400.00	68.77	2,045,600.00
210402	Тээвэр, шатахуун	74,244,400.00	65,240,200.00	87.87	9,004,200.00

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,516,100.00	3,845,528.48	87.87	9,004,200.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	14,720,900.00	13,976,900.00	69.71	1,670,571.52
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	23,655,500.00	21,554,260.00	94.95	744,000.00
2105	Нормативт зардал	248,385,800.00	226,188,955.50	91.12	2,101,240.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	153,664,400.00	154,998,908.50	91.06	22,196,844.50
210502	Хоол, хүнс	61,521,400.00	40,923,047.00	100.87	(1,334,508.50)
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	33,200,000.00	30,267,000.00	66.52	20,598,353.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	171,924,400.00	143,141,050.00	91.17	2,933,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	66,500,000.00	51,437,500.00	83.26	28,783,350.00
210602	Тавилга	55,000,000.00	47,042,800.00	77.35	15,062,500.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	16,660,000.00	16,660,000.00	85.53	7,957,200.00
210604	Урсгал засвар	33,764,400.00	28,000,750.00	100.00	-
2107	Томилолт, зочны зардал	9,500,100.00	9,500,000.00	82.93	5,763,650.00
210702	Дотоод албан томилолт	9,500,100.00	9,500,000.00	100.00	100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	25,609,600.00	22,479,868.00	100.00	100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	20,429,000.00	18,463,850.00	87.78	3,129,732.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	3,152,000.00	2,304,000.00	90.38	1,965,150.00
210803	Даатгалын үйлчилгээ	270,000.00	193,350.00	73.10	848,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	95,800.00	106,000.00	71.61	76,650.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	102,600.00	00.00	110.65	(10,200.00)
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	775,600.00	737,000.00	-	102,600.00
210807	Газрын төлбөр	85,400.00	71,568.00	95.02	38,600.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	699,200.00	604,100.00	83.80	13,832.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	28932000.00	17140150.00	86.40	95,100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	28,932,000.00	17,140,150.00	59.24	11,791,850.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	123,688,000.00	77,671,254.00	59.24	11,791,850.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	123,688,000.00	77,671,254.00	62.80	46,016,746.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	88,414,000.00	42,847,254.00	62.80	46,016,746.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	35,274,000.00	34,824,000.00	48.46	45,566,746.00
8	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	(22,474,100.00)	19,093,612.62		
9	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	22,474,100.00	(19,093,612.62)		
7	Харилцах болон хадгаламжийн дансны	22,474,100.00	(19,093,612.62)		

	цэвэр өөрчлөлт				
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	22,474,043.99		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	41,567,656.61		

Орон нутгийн төсвийн гүйцэтгэл:

төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	58,320,600.00	53,515,529.37	91.76	4,805,070.63
12	Татварын бус орлого	58,320,600.00	53,515,529.37	91.76	4,805,070.63
122	Тусламжийн орлого	58,320,600.00	53,515,529.37	91.76	4,805,070.63
122005	Төсвөөс санхүүжих	58,320,600.00	53,515,529.37	91.76	4,805,070.63
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	58,320,600.00	53,515,529.37	91.76	4,805,070.63
21	УРСГАЛ ЗАРДАЛ	58,320,600.00	53,515,529.37	91.76	4,805,070.63
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	58,320,600.00	53,515,529.37	91.76	4,805,070.63
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	58,320,600.00	53,515,529.37	91.76	4,805,070.63
210301	Гэрэл, цахилгаан	11,700,000.00	7,777,915.77	66.48	3,922,084.23
210302	Түлш, халаалт	44,220,600.00	43,337,613.60	98.00	882,986.40
210303	Цэвэр, бохир ус	2,400,000.00	2,400,000.00	100.00	-
8	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	-	-		
9	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	-		
7	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	-	-		
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-		

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 35,764.0 мянган төгрөгийн 8 алдаа, зөрчлийг илрүүлснээс 13,100.2 мянган төгрөгийн 2 алдааг залруулж, 22,663.8 мянган төгрөгийн 4 зөрчилд зөвлөмж өгч, нийцлийн аудитаар илрүүлсэн 2 зөрчилд зөрчил таслан зогсоох албан шаардлага хүргүүллээ.

3.1 Залруулсан алдаа

- Тус эрүүл мэндийн төв нь 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг бэлтгэж ирүүлэхдээ тайлант жилийн худалдан авах ажиллагааны тайланг бэлтгэж ирүүлээгүй, Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан төсөвт байгууллагын санхүүгийн тайлангийн маягтын дагуу бэлтгээгүй нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5.3 “тухайн жил худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэл;” заалттай нийцэхгүй байх тул аудитын явцад нөхөн гаргасан.
- Нийгмийн эрүүл мэндийн зардлаас бэлтгэсэн 13,100.2 мянган төгрөгийн хоол хүнс, бичиг хэргийн бараа материалыг үр дүнгийн тайланд бусад зардлаар бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4.1 “үнэн зөв байх”

заалттай нийцэхгүй “үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байх тул холбогдох зардлын данс уруу залруулга бичилт хийсэн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 22,663.8 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшин 26,549.3 мянган төгрөгөөс бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

3.2. Албан шаардлага

1. Шилэн дансны цахим хуудсанд 13 мэдээлэл хугацаа хоцроож оруулсан, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр хаягийг дутуу мэдээсэн, өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байгаа нь “Шилэн дансны тухай” хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх;”, 4.1.3 “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх;”, 6 дугаар зүйлийн 6.1.1 “тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө;”, 6.4.4 “таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг;” гэж заасныг тус тус хэрэгжүүлээгүй, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байх тул албан шаардлага хүргүүлсэн.
2. Тариалан сумын эрүүл мэндийн төв нь 2025 онд цахим дэлгүүрт байршсан 34,177.7 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгслийг шууд худалдан авсан байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т “Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно” гэж заасныг зөрчсөн, “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.3. Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Төсвийн гүйцэтгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тариалан сумын эрүүл мэндийн төвийн даргын 2025 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн Б/28 тушаалаар байгууллагын ажиллагсдыг Эрдэнэт медиал эмнэлэгт эрүүл мэндийн үзлэгт оруулахдаа хөдөлмөр хамгааллын зардлаас 16,660.0 мянган төгрөгийг зарцуулсан, байгууллагын шилдэг ажилтны шагналд 4,915.8 мянган төгрөгийг цалингийн зардлаас гаргасан, ажил олгогчоос олгох нийгмийн даатгалын шимтгэл, цалингийн бүлэг хооронд 1,088.0 мянган төгрөгийн гүйлгээг эдийн засгийн ангилал зөрчиж гүйлгээ хийсэн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” заалттай нийцэхгүй “үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төсвийг эдийн засгийн ангиллын дагуу зарцуулах

2. Төлбөртэй үйлчилгээний орлоготой холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тус эрүүл мэндийн төв нь үйлчлүүлэгчид үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээний төлбөрийн хэмжээ, жагсаалтыг гаргаж батлаагүй, шүдний эмчилгээний орлогыг огт төвлөрүүлээгүй байгаа нь Эрүүл мэндийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1 “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний санхүүжилт нь улсын төсөв, эрүүл мэндийн

даатгал, Засгийн газрын тусгай сан болон аж ахуйн нэгж, байгууллага, хамт олон, иргэний хандив, эрүүл мэндийн байгууллагын төлбөртэй тусламж, үйлчилгээ, бусад үйл ажиллагааны орлого, хууль тогтоомжоор хориглоогүй бусад эх үүсвэрээс бүрдэнэ.”, Эрүүл мэндийн сайдын 2022 оны “Жагсаалт, журам батлах тухай” А/216 дугаар тушаал, Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2022 оны 49/А/118 тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээ болон нэмэлт үйлчилгээ үзүүлж олсон орлогыг зарцуулах үлгэрчилсэн журам”-тай нийцэхгүй, “ нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Хууль журамд нийцүүлэн төлбөртэй тусламж үйлчилгээний жагсаалт, төлбөрийн хэмжээг баталж мөрдөх

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/			
							Үүнээс		Залруулсан	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Завсрын аудитаар:										
Авлагын бүртгэлтэй холбоотой	1	456.9			1	456.9	1	456.9		
Бараа материалын бүртгэлтэй холбоотой	1	790.5			1	790.5	1	790.5		
Зардлын бүртгэл тайлагнатай холбоотой	7	35,296.0			7	35,296.0	7	35,296.0		
Мөнгөн хөрөнгөтэй холбоотой	2	1,213.1			2	1,213.1	2	1,213.1		
Орлогын бүртгэлтэй холбоотой	1	1539.0			1	1539.0	1	1539.0		
Дүн	12	39,295.5			12	39,295.5	12	39,295.5		
Жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар:										
Батлагдсан маягтын дагуу тайланг бүрэн бэлтгэж ирүүлээгүй	1	0.0	1	0.0			1	0.0		
Нийгмийн эрүүл мэндийн зардаас гарсан зардлыг үр дүнгийн тайланд холбогдох зардлаар бүртгээгүй, бусад зардлаар тайлагнасан.	1	13,100.2			1	13,100.2	1	13,100.2		
Дүн	2	13,100.2	1	0.0	1	13,100.2	2	13,100.2		

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төсвийн эдийн засгийн ангилал зөрчиж гүйлгээ гаргасан.	1	22,663.8					1	22,663.8
Дүн	1	22,663.8					1	22,663.8

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны цахим хуудсанд мэдээлэх мэдээллүүдийг хугацаа хоцроосон.	1	-			1	-		
Цахим дэлгүүрээс худалдан авах боломжтой эм, хэрэгслийг шууд худалдан авсан.	1	-			1	-		
Дүн	2	-			2	-		

5. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл:

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
	НИЙТ	1	1			1			